

## САЛБАРЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН АЖИЛД ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ач холбогдол бүхий, инновацийн чиг баримжаатай судалгаа хөгжлийн ажлыг дэмжих зорилгоор судалгааны бүтээлийн багт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын нэрэмжит грант олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Судалгаа ба хөгжлийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн гүйцэтгэлээр сонгон шалгарсан нийт 5 багийг шилдэг бүтээлийн багаар шалгаруулна.
- 1.3. Грантын хэмжээ нь шилдэг бүтээл тус бүр 5 сая төгрөг байна.

### Хоёр. Сонгон шалгаруулалт

- 2.1. Грант горилогч нь сонгон шалгаруулалтанд дэвшүүлэх бүтээлээ тухайн салбарын харьяалагдах эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.
- 2.2. Харьяалах эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөл нь грантын шалгаруулалтад дэвшүүлэх 2 хүртэлх бүтээлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлд журамд заасан хугацаанд ирүүлнэ. Бүтээлээ дэвшүүлж буй баг эрдмийн зөвлөлийн дүгнэлтийн хамт дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 2.3. Бүрдүүлэх бичиг баримт нь дараах хэсгээс бүрдэнэ:
  - Бүтээлийн дэлгэрэнгүй танилцуулга /бүтээлийн нэр, гүйцэтгэгч багийн удирдагч болон гишүүдийн овог, нэр, албан тушаал, мэргэжил, боловсрол, эрдмийн зэрэг, цол, тухайн ажлыг эрхэлсэн хугацаа, судалгааны ажлын эхэлсэн, дууссан хугацаа/;
  - Үр дүнг нотолсон баримт, шинэлэг болон дэвшилттэй талын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - Үр дүнгийн эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - Үр дүнг шилжүүлэх, борлуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах боломжийн талаарх тодорхой санал;
- 2.4. Сонгон шалгаруулалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Салбар зөвлөлийн гишүүдийн саналыг нэгтгэж, хурлаас гарсан шийдвэрийг зөвлөлийн удирдлага Сайдад танилцуулна. Салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн грант олгох шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд гаргана.
- 2.5. Бүтээлийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтийг баримтлан шалгаруулна.
  - Шинжлэх ухааны багтаамж буюу технологийн түвшин;
  - Бүтээлийн техник, эдийн засгийн үзүүлэлт;
  - Зах зээлийн эргэлтэд орох чадамжийн түвшин буюу үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах бодит боломж;

- Ижил төстэй технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс давуу тал, өрсөлдөх чадвар, нэмүү өртөг бий болгож буй түвшин;

#### Гурав. Бичвэрийн эх бэлтгэлд тавих шаардлага

- 3.1. Бичвэрийг WORD программ дээр ARIAL шрифтээр, А4 форматаар, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1.0 -аар урд талаасаа 30 мм, дээд доод талаасаа 20 мм, баруун талаасаа буюу араасаа 15 мм зайтайгаар, ердийн стандарт хэлбэрээр бичсэн байх;
- 3.2. Бичвэрийг цаасан хэвлэмэл болон файл 2 хэлбэрээр хүлээж авна. Файл хэлбэрийн эхийг CD дээр буулгасан байна.
- 3.3. Хэвлэмэл болон CD дээр буулгасан материалыг хамтад нь дугтуйнд хийж битүүмжилсэн байна. Дугтуйн гадна талын зүүн дээд буланд ХХААХҮЯ, Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл, төв хэсэгт бүтээлийн нэр, баруун доод буланд гүйцэтгэсэн багийн мэдээлэл, хаяг, утас зэрэг холбоо барих мэдээллийг байршуулсан байна.

#### Дөрөв. Бүтээлийг ирүүлэх, шалгаруулах, мэдээлэх хугацаа

- 4.1. Грантын сонгон шалгаруулалтанд нэр дэвшүүлж буй бүтээлийг тухайн жилийн 04 дүгээр сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлд хаяглаж ирүүлнэ.
- 4.2. Ирүүлсэн бүтээлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар тухайн жилийн 05 дугаар сард багтаан хэлэлцүүлэн шалгаруулна.
- 4.3. Салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын тушаалаар батална.
- 4.4. Шалгаруулалтын дүн тухайн жилийн II дугаар улиралд багтаан эцэслэн гарах бөгөөд үр дүнгийн талаарх мэдээллийг тухайн бүтээлийн багийн удирдагчид мэдэгдэж, яамны цахим хуудсаар <http://www.mofa.gov.mn> зарлана.
- 4.5. Шилдэг бүтээлээр шалгарсан багт олгох грантыг тухайн жилийн III дугаар улиралд багтаан олгоно.

#### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ